



СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫН ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№107 /551/

2023.07.06

Цаг үе, үйл явдал

“ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛТЭЙ ЭРГҮҮЛ ХИЙХ ҮЕИЙН ГАР ХИЙЦИЙН ТЭСРЭХ БӨМБӨГИЙН АЮУЛ, ЗАНАЛХИЙЛЛЭЭС СЭРЭМЖЛЭХ, ХЯНАЛТ ҮЙЛДЭХ” СЭДЭВТ СУРГАЛТ АМЖИЛТТАЙ ӨНДӨРЛӨЛӨӨ



Монгол Улсын Зэвсэгт хүчин, ХБНГУ-ын Зэвсэгт хүчний сургалтын хөдөлгөөнт бүлэгтэй хамтарсан “Тээврийн хэрэгсэлтэй эргүүл хийх үеийн гар хийцийн тэсрэх бөмбөгийн аюул, заналхийллээс сэрэмжлэх, хяналт үйлдэх” сэдэвт сургалт 28 хоногийн турш үргэлжилж, амжилттай өндөрлөлөө.

НҮБ-ын Энхийг дэмжих ажиллагаанд Монгол Улсын Зэвсэгт хүчний Барилга-инженерийн салбарын илгээхтэй холбогдуулан сургалтын дэмжлэг авах талаарх манай талын хүсэлтийг ХБНГУ-ын Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний удирдлага хүлээн авч энэхүү хамтарсан сургалтыг зохион байгуулсан юм.

Тус сургалттай Батлан хамгаалахын дэд сайд Б.Баярмагнай, ХБНГУ-ын Гадаад хэргийн сайд А.Бербок, НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын цэргийн зөвлөх, генерал Б.Диоп, ХБНГУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайд Ё.Розенберг, тус улсын Берлиний цэргийн тойргийн командлагч бригадын генерал Ю.Ухтманн

тэргүүтэй төлөөлөгчид 6 дугаар сарын 14, 29, 30-ны өдөр танилцсан бөгөөд сургалт зохион байгуулж, оролцсон бие бүрэлдэхүүнд талархал илэрхийлж, амжилт хүссэн юм.

ХБНГУ-ын Гадаад хэргийн сайд Анналена Бербокийн айлчлалын дараа зохион байгуулагдсан тус сургалтын хаалтын ажиллагаанд Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлагч бригадын генерал Ч.Цогтжаргал, ХБНГУ-ын Батлан хамгаалахын атташе флотын адмирал Хэлгэ Риш нар оролцов.

Даян дэлхийн энх тайван тогтвортой байдлын хүрээнд Монгол Улс, ХБНГУ-ын Зэвсэгт хүчнүүд хамтран Афганистан улсад явагдсан НАТО-гийн тэргүүлсэн энхийг дэмжих олон улсын ажиллагаанд 2009-2021 онд үүргээ амжилттай гүйцэтгэсэн. Энэхүү ажиллагаа дуусгавар болсон ч хоёр орны Зэвсэгт хүчний хоорондын цэргийн хамтын ажиллагаа өргөжин хөгжиж байгаа талууд онцолж байсан ба хоёр орны Батлан хамгаалахын хамтын ажиллагааны

хүрээнд анх удаа гар хийцийн тэсрэх бөмбөгийн аюул, заналхийллээс сэрэмжлэх, хяналт үйлдэх сэдэвт хамтарсан сургалт амжилттай зохион байгуулагдаж өндөрлөлөө хэмээн Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлагч бригадын генерал Ч.Цогтжаргал тус сургалтын хаалтын ажиллагаанд оролцох үеэр хэллээ.

Тэрээр “Тус сургуульд оролцсон манай Зэвсэгт хүчний цэргийн алба хаагчдын НҮБ-ын Энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх ур чадвар дээшилсэн гэж дүгнэж байна. Мөн Энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх Монголын Зэвсэгт хүчний Барилга-инженерийн салбарын гүйцэтгэх үүрэгтэй уялдуулан цаашид энэхүү сургалтыг агуулга, хамрах цар хүрээний хувьд өргөжүүлэн хөгжүүлэх зорилтыг бид тавьж байгаа билээ. Ингээд сургалтыг амжилттай зохион байгуулж, өөрсдийн мэдлэг, ур чадвар, ажиллагааны арга туршлагаа харамгүй хуваалцсан ХБНГУ-ын Зэвсэгт хүчний сургалтын хөдөлгөөнт бүлгийн бүрэлдэхүүнд баяр хүргэж, цаашдын ажилд нь өндөр амжилт хүсэн ерөөе. Тус сургалтад идэвх зүтгэл сахилга зохион байгуулалттай оролцож, Герман нөхдөөсөө ихийг сурч, өөрсдийн мэдлэг, ур чадвараа дээшлүүлсэн та бүхэнд баяр хүргэж, цаашдынх нь ажил, албанд амжилт хүсье” гэлээ.

Мөн ХБНГУ-ын Зэвсэгт хүчний сургалтын хөдөлгөөнт бүлгийн дарга дэд хурандаа Прэссентин “Та бүхний өмнө зогсоод нээлтийн арга хэмжээнд үг хэлж байсан нь өчигдөрхөн мэт болов ч хэдийнээ 4 долоо хоног өнгөрсөн байна. Тэр үед би хэлсэн үгэндээ энэ сургалтаар бид Монголын цэргийн алба хаагчдыг сургах, мөн тэднээс суралцах талаар онцолж байсан. Мөн миний хувьд болон манай сургалтын хөдөлгөөнт бүлгийн бүрэлдэхүүний хувьд Монгол орон, ард түмнийх нь соёл, ёс уламжлалтай танилцах боломж гарч байна гэж хэлж байсан. Бидний үндсэн зорилго нь Монгол Улсын Зэвсэгт хүчний төлөвлөгөөт НҮБ-ын энхийг дэмжих ажиллагаанд бэлтгэхэд хувь нэмрээ оруулах явдал байсан. Сурах хүсэл эрмэлзэлтэй, хичээнгүй, сахилга бат маш сайн цэргийн алба хаагчидтай хамтран ажилласны үр дүнд бид зорилгодоо хүрсэн гэж би үзэж байна. Монгол орны өв соёлыг бидэнд таниулах ажлыг сургалттай уялдуулан зохион байгуулж чадсанд Та бүхэндээ гүн талархсанаа илэрхийлье” гэж онцоллоо.



ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 350 ГАРУЙ ЦЭРГИЙН АЛБА ХААГЧ ҮЕРИЙН ГОЛОМТОД АЖИЛЛАЖ БАЙНА



Нийслэлд үргэлжлэн орсон борооны улмаас БЗД-ийн 43 дугаар хороо, СБД-ийн 1 дүгээр хорооны нутаг дэвсгэрт Сэлбэ голын усны түвшин нэмэгдэн үерийн далан хальсан. Үүнтэй холбоотойгоор өчигдөр буюу энэ сарын 5-ны өдрийн 20:00 цагаас эхлэн Зэвсэгт хүчний алба хаагчид Сэлбэ голын дагуу үерийн усны аюулаас иргэдийн амь нас, эд хөрөнгийг авран хамгаалах, гамшгийн хор уршгийг арилгах, сэргээн босгоход хүч нэмэгдүүлэн ажиллаж эхэлсэн. Тэгвэл өнөөдөр үерийн голомтод ажиллах цэргийн алба хаагчдын тоог 150-иар нэмэгдүүллээ. Ингэснээр Зэвсэгт хүчний 6 ангийн 350 цэргийн алба хаагч, 6 хүнд даацын техниктэйгээр Баянзүрх дүүргийн 13, Сүхбаатар дүүргийн 1, 12, 13 дугаар хорооны нутаг дэвсгэрт далан байгуулах, шороо татах ажлыг эхлүүлээд байна.



ЦАГ АГААР

УЛААНБААТАР

| ӨДӨР | ШӨНӨ |
|-------|-------|
| ☀️ 21 | ☁️ 10 |

ӨМНӨД СУДАН

| ӨДӨР | ШӨНӨ |
|-------|-------|
| ☀️ 36 | ☁️ 24 |

ВАЛҮТЫН ХАНШ

| ВАЛҮТ | АВАХ | ЗАРАХ |
|--------|--------|-------|
| USD 🇺🇸 | 3,428 | 3,434 |
| EUR 🇪🇺 | 3,740 | 3,756 |
| CNY 🇨🇳 | 476.50 | 479 |
| RUB 🇷🇺 | 39,30 | 40.40 |
| JPY 🇯🇵 | 23.80 | 24.50 |
| KRW 🇰🇷 | 2.61 | 2.63 |

ЗУРХАЙ



2023.07.06 /ПҮРЭВ ГАРАГ/
БИЛГИЙН ТООЛЛЫН 18

**ЗУНЫ ДУНД ШАР МОРЬ САР
ЕСӨН УЛААН МЭНГЭТЭЙ
ХӨХӨГЧИН ҮХЭР ӨДӨР**

Үс засуулбал:

**ЭД МАЛЫН ГАРЛАГАТАЙ
НАРАН УРГАХ, ШИНГЭХ:
05.00-20.53**

Барилдлага:

Үл зохилдох

ШҮТЭН БАРИЛДАГА:

Нэр өнгө

Тухайн өдөр бар, туулай, бич, тахиа жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр андгай тангаргаас няцах, дайсныг номхруулах үйлд сайн. / муу найз нөхрөөс холдож салахад ээлтэй өдөр/, үйл буруутгах, ламд золгох зэрэг цагаан зүгийн үйлэнд сайн. Баруун нүд татвал холын сураг сонсох, зүүн нь татвал эд олдох, баруун чих хангинавал ундаа олдох, зүүн чих хангинавал түлэгдэх, нохой уливал үхсэний сураг сонсох, хэрээ дуугарвал нөхөртэй учрах, тагнай загатнавал хувцас олдох, бие татвал эцэг, эхэд муу. Хөл татвал хэрүүл, тэмцэл гарах муу ёр болой.

КОРОНАВИРУС ДЭЛХИ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 690,980,978

Эдгэрсэн

Нийт: 663,500,472

Нас барсан

Нийт: 6,896,089

Цахим шууданд

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ АЛБА ХААГЧИД ХИЙМЭЛ ДАЛАН БАЙГУУЛАХ, НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, ТАТАН ГАРГАХ АЖЛЫГ ГҮЙЦЭТГЭЖ БАЙНА



350 дугаар ангийн долоон хүний бүрэлдэхүүнтэй бүлэг, Аврах гал унтраах 34 дүгээр ангийн алба хаагчидтай хамтран нүүлгэн шилжүүлэх, эд хогшлыг татан гаргахаар ажиллаж байна.

Мөн тус бүр 10 хүний бүрэлдэхүүнтэй хоёр бүлэг Сүхбаатар дүүргийн 19, 17 дугаар хороодод байрлах Баянбулаг, Гоодойн гүүрэнд ажиллаж, эргийг үерийн уснаас хамгаалах бэхлэлт хийх, хиймэл далан байгуулах ажлыг гүйцэтгэж байгаа аж.



Нийслэл хотод үүсээд ажиллаж байна. Энэ хүрээнд буй үер усны гамшгаас хамгаалах нэгдсэн арга Сонгинохайрхан дүүргийн 15 хэмжээнд Зэвсэгт хүчний 400 дугаар хорооны 84 гаруй цэргийн алба хаагч, 6 гудамжны оршин суугчид болох нэгж техниктэйгээр өдөр шөнө, нэг хашааны хоёр айл үерт цагийн бэрхшээлийг үл хайхран автсан байсныг Зэвсэгт хүчний

УЛСЫН ОНЦГОЙ КОМИССООС ДАРААХ ШИЙДВЭРҮҮДИЙГ ГАРГАВ



бэлэн байдлыг хангах, болзошгүй халдварт өвчний тархалтаас урьдчилан сэргийлэх, сэрэмжлүүлэг мэдээ, мэдээллийг түгээж ажиллахыг Эрүүл мэндийн сайд С.Чинзоригт даалгалаа.

Мөн Нийслэлийн хэмжээнд үүсээд байгаад нөхцөл байдалд хариу арга хэмжээг яаралтай авч, болзошгүй эсрдэлээс урьдчилан сэргийлэх, ариутгал, халдваргүйжүүлэлт хийх зэрэг ажлуудыг шуурхай зохион байгуулахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумьяабазарт үүрэг болгож, ОБЕГ дээр шуурхай штаб байгуулж, нийт алба хаагчид өндөржүүлсэн бэлэн байдалд шилжин ажиллах шийдвэрийг гаргалаа.

Түүнчлэн Зоонозын Өвчин Судлалын төв, Нийгмийн Эрүүл мэндийн хүрээлэн болон орон нутгийн Эрүүл мэндийн байгууллагууд болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх, халдварт өвчин тархах эрсдэл нэмэгдэж болзошгүй тул бэлтгэл бэлэн байдлыг хангах, аймаг, орон нутгийн удирдлагууд болзошгүй аюулаас урьдчилэн сэргийлж, далан шуудууг цэвэрлэх, сэргээх, гүүр, ус зайлуулах хоолойг хүчитгэх, өргөтгөлийн ажлыг эрчимжүүлэхийг анхаарууллаа.

Нийслэл хотод үргэлжлэн орсон борооны улмаас үүссэн нөхцөл байдалтай холбоотойгоор УОК-ын хуралдаан боллоо.

Хуралдаанаар УОК-ын дарга, Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан Сэлбэ, Дунд гол үерлэсний улмаас усанд автсан барилга байгууламжаас ус соруулах, үерийн далангийн суваг шуудууг өртөгтгөх арга хэмжээнд шаадлагатай техникийг шуурхай дайчлан гаргах, Нийслэлийн онцгой комисст дэмжлэг үзүүлж ажиллахыг Батлан хамгаалахын сайд, Улсын онцгой комиссын орлогч дарга Г.Сайханбаяр, Барилга хот, байгуулалтын сайд Ц.Даваасүрэн нарт даалгасан бол үерийн улмаас халдварт өвчин тархах эрсдэл нэмэгдэх тул эрүүл мэндийн байгууллагуудын бэлтгэл,

Гэрэл зураг түүх өгүүлнэ



Үерийн голомтод үүрэг гүйцэтгэж буй цэргийн бүсгүйчүүд
Эх сурвалж: ЗАРИГ

БХЭШХ-ИЙН ГОЛ ТҮНШ - ШИНЖЛЭХ УХААН ТЕХНОЛОГИЙН САН



БХЭШХ-ийн судалгаа шинжилгээ, инновац, үйлдвэрлэлийн үйл ажиллагааг Монгол Улсын БШУЯ, ШУА, ШУТУЗ, ШУТС зэрэг байгууллагууд байнга дэмжин аюулгүй байдал, батлан хамгаалах бодлого, цэргийн шинжлэх ухааны судалгаа хөгжүүлэлтийг эрчимжүүлэх, гарсан үр дүн, ач холбогдлыг дэлгэрүүлэхэд чиглэсэн олон талт ажлуудыг хамтран зохион байгуулж ирсэнд бид үргэлж талархаж байдгаа илэрхийлэхийн хамт Та бүхний эрдэм судлалын ажилд өндөр амжилтыг хүсэн ерөөе.

Сүүлийн 20 гаруй жилийн хугацаанд БХЯ-ны ШУТС-ийн захиалгаар батлан хамгаалах салбарт суурь болон салбарын хэрэгцээт судалгаа шинжилгээний 30 орчим төслийн ажлыг ШУТС-аас санхүүжүүлсэн байдаг. Эдгээр төсөлт ажлуудын дийлэнхийг батлан хамгаалах салбарын эрдэм шинжилгээний ууган байгууллага болох Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэн дангаар гүйцэтгэж ирсэн.


Тус хүрээлэн нь 2021-2023 онд ШУТС-ын санхүүжилтээр суурь судалгааны 2 төслийн ажил, салбарын захиалгат 5 төслийн ажлыг амжилттай хэрэгжүүлэн үр дүнг хүлээлгэж өгөөд байна.

Тухайлбал, Монгол Улсын "Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн", доктор (Sc.D), профессор О.Үржингийн удирдлагаар "Монгол Улсын аюулгүй байдлыг хангахад "гуравдагч хөрш"-ийн бодлогын үзүүлэх нөлөөлөл" төслийн ажил гүйцэтгэж, түүний үр дүнд Монгол Улсын "гуравдагч хөрш"-ийн бодлого ба хоёр хөрштэй тэнцвэртэй харилцах бодлогын парадигм, "Аюулгүй байдал ба "гуравдагч хөрш"-ийн бодлого" нэг сэдэвт бүтээл туурвисан болно. Мөн доктор (Ph.D), профессор, бригадын генерал Ч.Сосорбарам удирдагчтай төслийн баг "Үндэсний ой санамж, үнэт зүйлсийг сэргээн тодорхойлох замаар үндэсний аюулгүй байдлыг бэхжүүлэх нь" сэдэвт төслийн ажил гүйцэтгэж, түүний үр дүнгээр Монгол Улсын иргэдэд үндэсний ой санамж, үнэт зүйлсийн талаарх судалгааны санал, зөвлөмж боловсруулсан ба "Үндэсний ой санамж, үнэт зүйлс" сэдэвт судалгааны бүтээл хэвлүүлэн олны хүртээл болгоод байна. Түүнчлэн доктор (Sc.D), профессор А.Хүү-Ухна удирдагчтай төслийн баг "Тийрэлтэт сумны хатуу түлш үйлдвэрлэх технологи боловсруулах" төслийн ажлыг гүйцэтгэж, түүний үр дүнгээр Монгол орны тэсрэх бодис, дарийн түүхий эдийн судалгаа хийгдэн, батлан хамгаалах аж үйлдвэрийг хөгжүүлэх, түүнчлэн улс ардын аж ахуй, уул уурхайн тэсрэх бодис, хэрэглээний химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх бололцоотойг нотлон, "Пиротехник судлал" - 3 боть, "Тийрэлтэт сум, пуужингийн хатуу түлш", "Хатуу түлштэй сургалтын хэрэгсэл, гранатыг бэлтгэх", цэргийн сургалтад хэрэглэх аргачлал зэрэг онол, арга зүйн 5 бүтээл хэвлүүлсэн.

2024 онд түүхт 45 жилийнхээ ойг тэмдэглэх БХЭШХ нь шинжлэх ухааны хөгжил, судалгаа хөгжүүлэлтийн ажлыг санхүүжүүлж бодит дэмжлэг үзүүлж ирсэн БШУЯ, ШУА, ШУТУЗ, ШУТС болон хамтран ажилладаг судалгааны хүрээлэнгүүд, МУИС, ШУТИС, ХААИС, БИС зэрэг байгууллагуудтай нягт холбоотой ажиллаж, улс орны аюулгүй байдлыг хангах, цэргийн шинжлэх ухааныг хөгжүүлэх үйлсдээ өндөр амжилт гаргах зориг, эрмэлзэл дүүрэн ажиллаж байна.

БАТЛАН ХАМГААЛАХЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХҮРЭЭЛЭН

НУРАХ ЭРСДЭЛТЭЙ НАТУРЫН ГҮҮРЭНД ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 50 ГАРУЙ АЛБА ХААГЧ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭЖ БАЙНА



далан босгох, элс хайрга зөөх, шуудайлах ажлыг гүйцэтгэж байна.

Одоогийн байдлаар үерийн усны түвшин өглөөнийхөөс 40 см-ээр доошилсон гэдэг мэдээллийг холбогдох албаныхан өглөө.



Нийслэл Улаанбаатар хотод үүссэн үерийн усны гамшгийн улмаас Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэрт байрлах Натурын гүүрийн зорчих хөдөлгөөнийг 17:00 цагийн орчимд тодорхойгүй хугацаагаар зогсоосон. Тэгвэл нурах эрсдэл үүсээд буй Натурын гүүрэнд Зэвсэгт хүчний 084, 032, 284 дүгээр ангийн 50 гаруй алба хаагч ажиллаж, Онцгой байдлын байгууллага, Хил хамгаалах албаны бүрэлдэхүүнтэй хамтран